УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 28 өдөр Дугаар А/18 Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/50 дугаар тогтоол, 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/236, 2025 оны 04 дугаар сарын 10-ны өдрийн "Арга хэмжээ зохион байгуулах тухай" А/470, "Хөрөнгө гаргах тухай" А/471 дүгээр захирамжуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улс, Унгар Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойн хүрээнд хоёр орны найрсаг хамтын ажиллагааг хөгжүүлэх, үндэсний соёлын үнэт зүйлсийг сурталчлах зорилгоор "Улаанбаатар хотын соёлын өдрүүд" арга хэмжээний хүрээнд "Нүүдэлчдийн нийслэл хот" гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 49,974,600 (дөчин есөн сая есөн зуун далан дөрвөн мянга зургаан зуу) төгрөгийн хөрөнгийг нэмэлт төсвийн бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч (Ж.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Үзэсгэлэн зохион байгуулахтай холбоотой бараа, ажил үйлчилгээг гүйцэтгэх байгууллагыг судлан, гэрээ байгуулж ажиллахыг менежер (Б.Нарангэрэл), арга зүйч (Б.Өлзийбаяр), эрдэм шинжилгээний ажилтан (Г.Очбаяр), дизайнер (С.Эрдэнэбат) нарт даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг менежер (Б.Нарангэрэл)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ П.ДАВААСҮРЭН

9097104 СТА3737 9022031489

2025/alban hereg/A tush/docx
13600100 45

Музейн захирлын 2025 оны 04
дүгээр сарын 28 -ны өдрийн
А/18 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛС, УНГАР УЛС ХООРОНД ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООСНЫ 75 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД БУДАПЕШТ ХОТНОО
“УЛААНБААТАРЫН СОЁЛЫН ӨДРҮҮД”-ИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
“НҮҮДЭЛЧДИЙН НИЙСЛЭЛ ХОТ” ГЭРЭЛ ЗУРГИЙН ТУСГАЙ ҮЗЭСГЭЛЭНГИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Бараа, ажил үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Тайлбар
Нэг. Үзэсгэлэнгийн гэрэл зураг, жааз худалдан авах, угаалгах, наах зардал						
1.	Гэрэл зураг худалдаж авах зардал	ш	50	100,000	5,000,000	Нягтаршил сайтай эх хувь зургийг мэргэжилийн байгууллагаас худалдан авах
2.	Гэрэл зургийг жаазлах зардал (60х80 см)	ш	72	90,000	6,480,000	Жааз: Хөнгөн цагаан, Нүүрэвч: 2 мм зузаан, тунгалаг, зориулалтын өлгүүр, тросстой.
3.	Гэрэл зураг томруулж буулгах зардал (60х80 см)	ш	72	91,800	6,609,600	Олон улсын гэрэл зургийн үзэсгэлэнгийн зориулалттай, стандартад нийцсэн тосон хороор хэвлэнэ. (Өнгө будгийн тохируулалт сайтай, удаан хадгалах)
4.	Гэрэл зургийн металл хавтан авах зардал	ш	72	18,000	1,296,000	Хүчилгүй, үзэсгэлэнгийн стандарт хангасан.
5.	Буулгасан зургийг металл хавтанд наах зардал	ш	72	7,000	504,000	Удаан хугацааны хадгалалт даах, температурын өөрчлөлтөд тэсвэртэй наалт
	Дүн				**19,889,600**	
Хоёр. Гэрэл зураг, жааз, хөл зэргийг тээвэрлэхэд шаардагдах хайрцаг хийлгэх, савлах, боох, тээвэрлэх зардал						
6.	Үзэсгэлэнгийн гэрэл зураг бусад зүйлсийг хийх хайрцаг авах	ш/хайрцаг	4	600,000	2,400,000	Гэрэл зургууд, бусад зүйлсийг гэмтэхээс сэргийлсэн зориулалтын модон хайрцагт хийж тээвэрлэнэ.

7.	Каргод ачихад аюулгүй савлагааны материал, баглаж боох, савлах	багц	1	400,000	400,000	Гэрэл зураг бусад зүйлсийг аюулгүй тээвэрлэх сав баглаа боодлын зөөлөвч, материалууд, түлхүүр цоож
8.	Карго компанийн агуулахад хүргэх тээврийн зардал	рейс	2	200,000	400,000	Дүнжингарав-Улаанбаатар хотын музей- ТЭЦ-4 ложистик агуулах ТЭЦ-4 ложистик агуулах-Улаанбаатар хотын музей
	Дүн				**3,200,000**	
Гурав. Үзэсгэлэнгийн анонс хэвлүүлэх, тараах материал хэвлүүлэх зардал						
9.	Үзэсгэлэнгийн анонс, хаяг хэвлэх загвар гаргах зардал	ш	6	250,000	1,500,000	Үзэсгэлэнгийн тухай товч тайлбар, агуулга бичсэн 180х80 см хэмжээтэй хэвлэмэл анонс байна.
10.	Анонсын хөл стэнд	ш	6	85,000	510,000	Хэвлэмэл анонсын хөл
11.	Тараах материал эх бэлтгэх, хэвлэх	ш	200	9,000	1,800,000	Үзэсгэлэнтэй холбоотой зар сурталчилгааны тараах танилцуулга боршур
	Дүн				**3,810,000**	
Дөрөв. Баримтат кино, кино мэдээ худалдан авах зардал						
12.	2 анги бүхий 4 бүлэг баримтат кино, Кино мэдээ 20 дугаар, 20 ширхэг гэрэл зураг худалдан авах	багц	1	500,000	500,000	Архивын Ерөнхий газраас Унгар улстай холбоотой баримтат кино 2, кино мэдээ 20, гэрэл зураг 20 ширхэгийг тус тус худалдан авна.
	Дүн				**500,000**	
Тав. Гэрэл зургийн тайлбар, орчуулга хийлгэх, баримтад киноны хадмал хийлгүүлэх ажлын хөлс						
13.	Зургийн тайлбар бичих, орчуулах, хэвлэх зардал	ш	72	40,000	2,880,000	Унгар, Англи хэлээр тайлбартай байна.
14.	Баримтад кино болон мэдээ сюжетэд унгар хэлээр хадмал хийх	багц	1	3,562,400	3,562,400	Монгол текстэд хөрвүүлсэний дараа унгар хэл рүү хөрвүүлж хадмалаар байршуулах

	Дүн				**6,442,400**	
Зургаа. Гэрэл зураг байрлуулах тавцан хөл худалдан авах зардал						
15.	Гэрэл зураг байрлуулах тавцан, хөл /чанартай/	ш	74	85,000	6,290,000	Зураг бүрийг харааны түвшинд тохирсон зориулалтын үзэсгэлэнгийн хөл дээр байрлуулна.
	Дүн				**6,290,000**	
Долоо. Үзэсгэлэн зохион байгуулж байгаа ажилтнуудын хоол, унааны зардал						
16.	Үзэсгэлэн зохион байгуулагчдын өдрийн хоолны зардал	Өдөр хүн	хоног 5 хүн 7	138,360	4,842,600	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/470 дугаар захирамжийн дагуу хоол унааны зардал 5 ажилтанд олгохоор тооцов.
	Дүн				**4,842,600**	
	Найм. Унгарын Будапешт хотод үзэсгэлэн зохион байгуулахад шаардагдах тоног төхөөрөмжийн түрээс, орчуулагчийн ажлын хөлс бусад зардал					
17.	Үзэсгэлэнд хэрэглэгдэх нэмэлт жижиг хэрэглэл, тоног төхөөрөмжийн түрээсийн зардал, орчуулагчийн ажлын хөлс	багц	1	5,000,000	5,000,000	Баримтад кино, мэдээ бичлэгийг гаргах дэлгэц, тайлбар хийхэд ашиглах микрофон зэрэг тоног төхөөрөмжийн түрээсийн зардал, орчуулагчийн ажлын хөлс
	Дүн				**5,000,000**	
	Нийт дүн				**49,974,600**	